



ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2017 оны эхний 4 сар



ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХҮСНЭГТ 1. МАЛЫН ТОО, жилийн эцэс, хороогоор, төрлөөр

	1 хороо	2 хороо	3 хороо	4 хороо	5 хороо	Дүүргийн дүн
Тэмээ	72	-	135	2	-	209
Адуу	4568	724	3174	3168	2409	14043
Үхэр	4318	1143	3204	3461	2072	14198
Хонь	26332	6028	22823	23922	12166	91271
Ямаа	16917	3943	14603	15290	8300	59053
	52207	11838	43939	45843	24947	178774

ХҮСНЭГТ 2. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ, өссөн дүнгээр, эхний 4 сараар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Суурин хүн ам	тоо	26905	27036	27440	27936	28333	28419	28973	
Төрөлт	тоо	162	141	145	185	197	183	155	125
Нас баралт	тоо	36	45	35	51	45	47	43	30
Шилжиж ирсэн	тоо	379	196	207	289	253	255	305	242
Шилжиж явсан	тоо	405	215	272	330	282	249	364	276
Цэвэр өсөлт	хувь	0.47	0.36	0.40	0.48	0.54	0.48	0.39	0.32'
Механик өсөлт	хувь	-0.10	-0.07	-0.24	-0.15	-0.10	0.02	-0.20	-0.11'

' – өмнөх оны суурин хүн амаас тооцов.




АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 2017 оны эхний 4 сарын байдлаар 45.3 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 10.3 хувиар буюу 4.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт


Үзүүлэлт	Нийт үйлдвэрлэлт /биет хэмжээгээр/			Нийт үйлдвэрлэлт /үнийн дүнгээр, мянган төгрөг/		
	2016 I-IV	2017 I-IV	өсөлт бууралт	2016 I-IV	2017 I-IV	өсөлт бууралт
Нүүрс олборлолт	1403.7	1446.4	42.7	38601750.0	42668800.0	4067050.0
Дулаан дамжуулалт	76.6	77.8	1.2	2280498.6	2429518.3	149019.7
Талх үйлдвэрлэлт	41.4	38.1	-3.3	51805.2	54057.0	2251.8
Нарийн боов үйлдвэрлэлт	49.1	26.5	-22.6	116790.3	109175.4	-7614.9

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /биет хэмжээгээр/ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт 3.0 хувиар буюу 42.7 мянган тонноор, дулаан дамжуулалт 1.6 хувиар буюу 1.2 мянган гкал-аар тус тус өссөн бол, талх үйлдвэрлэлт 8.0 хувиар буюу 3.3 тонноор, нарийн боов үйлдвэрлэлт 46.0 хувиар буюу 22.6 тонноор тус тус буурсан байна.


Зураг 1. Нүүрс олборлолт, сая төгрөг, сараар



Зураг 2. Талх, нарийн боов үйлдвэрлэлт, мянган төгрөг, сараар



Зураг 3. Нүүрс олборлолт, мянган тонн, жил бүрийн I-IV сар



Харин аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл /үнийн дүнгээр/ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт 10.5 хувиар буюу 4067.1 сая төгрөгөөр, дулаан дамжуулалт 6.5 хувиар буюу 149.0 сая төгрөгөөр, талх үйлдвэрлэлт 4.3 хувиар буюу 2.3 сая төгрөгөөр тус тус өссөн бол нарийн боов үйлдвэрлэлт 6.5 хувиар буюу 7.6 сая төгрөгөөр буурсан байна.




НИЙГМИЙН ДААТГАЛ:

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн орлого 5808.2 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 2 дахин буюу 2961.0 сая төгрөгөөр, зарлага 7468.4 сая төгрөг болж 46.6 хувиар буюу 2376.4 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт орлогын 61.1 хувь буюу 3549.1 сая төгрөгийг тэтгэврийн сангаас, 7.0 хувь буюу 404.0 сая төгрөгийг тэтгэмжийн сангаас, 10.8 хувь буюу 626.5 сая төгрөгийг ҮОМШӨ сангаас, 19.5 хувь буюу 1134.2 сая төгрөг нь эрүүл мэндийн даатгалын сангаас, 1.6 хувь буюу 94.4 сая төгрөгийг ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.

Зураг 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага сая төгрөг, сараар




Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016		2017		2017.IV% 2016.IV	2017.I-IV% 2016.I-IV
	IV	I-IV	IV	I-IV		
Сангийн орлого бүгд	1129.9	2847.2	1509.2	5808.2	133.5	2.0*
тэтгэврийн сан	156.2	1171.3	931.1	3549.1	5.0*	3.0*
тэтгэмжийн сан	78.2	192.1	106.0	404.0	135.5	2.0*
ажилгүйдлийн сан	19.4	47.2	24.4	94.4	125.7	2.0*
ҮОМШӨ-ний сан	123.7	302.8	164.5	626.5	133.0	2.0*
ЭМД-ын сан	212.5	593.9	283.2	1134.2	133.3	190.9
Сангийн зарлага бүгд	1754.4	5092.0	1850.3	7468.4	105.5	146.6
тэтгэврийн сан	1177.5	3517.5	1325.5	5262.0	112.5	149.5
тэтгэмжийн сан	81.5	209.5	84.6	302.0	103.8	144.2

ҮОМШӨ-ний сан	132.0	430.0	150.1	584.1	113.7	135.8
ЭМД-ын сан	333.0	859.0	265.2	1200.3	79.6	139.7
ажилгүйдлийн сан	30.4	76.0	25.0	120.0	82.2	157.8

*дахин


Зураг 5. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц /хувиар/



Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 4058 хүнд 5262.0 сая төгрөгийн тэтгэвэр, 1155 хүнд 302.0 сая төгрөгийн тэтгэмж, 428 хүнд 584.1 сая төгрөгийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 34684 хүнд 1200.3 сая төгрөгийн эрүүл мэндийн даатгал, 67 хүнд 120.0 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.

НИЙГМИЙН ХАЛАМЖ: 2017 оны эхний 4 байдлаар нийгмийн халамжийн сангийн орлого 1025.8 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 12.5 хувиар буюу 113.7 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт орлогын 391.7 сая төгрөг буюу 38.2 хувь нь улсын төсвөөс, 628.8 сая төгрөг буюу 61.3 хувь нь орон нутгийн төсвөөс, 5.2 сая төгрөг буюу 0.5 хувь нь бусад орлогоор тус тус санхүүжигдсэн байна.



Зураг 6. Нийт орлого 1025.8 сая төгрөг

Хүснэгт 5. Нийгмийн халамжийн сангийн орлого, зардал, сая төгрөг

Үзүүлэлт	2016		2017		2017.IV% 2016.IV	2017.I-IV% 2016.I-IV
	IV	I-IV	IV	I-IV		
Нийгмийн халамжийн сангийн орлого	131338.7	912009.4	113876.8	102576.3	86.7	11.2
Улсын төсвөөс	6000.0	324000.0	6100.0	391690.0	101.7	120.9
Орон нутгийн төсвөөс	124921.0	584290.5	107335.5	62863.2	85.9	10.8
Бусад орлого	417.7	3718.9	441.5	5243.1	105.7	141.0
Нийгмийн халамжийн сангийн зарлага	139817.9	822939.0	148353.9	952000.5	106.1	115.7
Тэтгэвэр	50900.0	227823.7	63252.1	251915.7	124.3	110.6
Тэтгэмж	31208.5	120480.1	29122.0	128029.6	93.3	106.3
"Алдарт эх" 1 одонтой эхчүүд	2800.0	142800.0	1800.0	138040.0	64.3	96.7
"Алдарт эх" 2 одонтой эхчүүд	2300.0	124000.0	3900.0	130300.0	169.6	105.1
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	20933.3	97890.7	23225.3	92276.0	110.9	94.3
Насны хишиг	-	-	760.0	102610.0	-	-
Ахмад дайчин, гавьяатын нэмэгдэл	3000.0	13020.0	2800.0	11000.0	93.3	84.5
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	144721.1	35569.9	6977.8	33178.0	4.8	93.3
ХБИргэнд үзүүлсэн хөнгөлөлт	2047.5	16329.8	3748.0	11803.0	183.1	72.3
"Хүнс тэжээл" халамжийн хөтөлбөр	12031.5	35854.0	12330.5	50043.5	102.5	139.6
ОНО-д түшиглэсэн халамж	-	-	-	390.0	-	-
Бусад үйлчилгээ	125.0	9160.8	438.2	2414.7	350.6	26.4

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 473 хүнд 251.9 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 521 хүнд 128.0 сая төгрөгийн тэтгэмж, “Алдарт эх”-ийн одонтой 1989 хүнд 268.3 сая төгрөг, 753 жирэмсэн эхчүүдэд 92.3 сая төгрөгийн тэтгэмж, 1254 хүнд 102.6 сая төгрөгийн насны хишиг, 18 ахмад дайчин, гавъяат цолтой хүнд 11.0 сая төгрөг, 1217 ахмад настанд 33.2 сая төгрөгийн хөнгөлөлт, 1273 хүнд 50.0 сая төгрөгийн хүнс тэжээлийн хөтөлбөрт, 83 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 11.8 сая төгрөгийн хөнгөлөлт тус тус олгосон байна.




НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын нийт орлого 511.1 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 10.4 хувиар буюу 59.1 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт орлогын 329.9 сая төгрөг буюу 64.5 хувь нь хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

Хүснэгт 6. Орон сууц нийтийн аж ахуйн орлогын байдал. мянган төгрөг

Үзүүлэлт	2016 он	2017 он	Өсөлт бууралт
Орон сууц	56430.2	57962.4	1532.2
Ус борлуулалт-бүгд	257316.0	231339.1	-25976.9
үүнээс: хүн амд	150474.2	136939.8	-13534.4
аж ахуйн нэгжид	101829.6	91549.8	-10279.8
үйлчилгээний байгууллагад	5012.2	2849.4	-2162.8
Сувагжуулалт	206052.9	185484.9	-20568.0
Бусад	50428.0	36320.1	-14107.9
Дүн	570227.1	511106.5	-59120.6

Зураг 7. Нийтийн үйлчилгээний салбарын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл мянган төгрөг, сараар



**СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБОО:**

2017 оны эхний 4 сарын байдлаар дүүргийн сууц өмчлөгчдийн холбоодын орлогын төлөвлөгөөний биелэлт доорх байдалтай байна.

Хүснэгт 7. Сууц өмчлөгчдийн холбоодын орлогын биелэлт мянган төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
Тавлаг өргөө	27339.8	21629.6	79.1
Маргад өргөө	24647.7	22654.8	91.9
Сод хөгжил	33704.4	27228.2	80.8
Шинэ элч	21049.2	22150.5	105.2
Уурхайчин	16376.0	13127.0	80.2
НИЙТ ДҮН	123117.1	106790.1	86.7


**ЭРҮҮЛ МЭНД:**

Дүүрэгт эхний 4 сарын байдлаар 188 эх амаржиж, 188 хүүхэд төрүүлснээс гадны 34 эх амаржсан байна. Энэ хугацаанд 80243 хүн амбулаторын үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс 323 хүнээр буюу 0.4 хувиар, 2866 хүн хэвтэн эмчлүүлсэн байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 47 хүнээр буюу 1.6 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 8. Бүртгэгдсэн халдварт өвчин

Үзүүлэлт	2016 I-IV	2017 I-IV	Өсөлт бууралт
Халдварт, паразит өвчин	93	56	-37
Заг хүйтэн	34	21	-13
Тэмбүү	31	16	-15
Мөөгөнцөр /кандидоз/	9	-	-9
Трихомониаз	18	19	1
Кандилом	1	-	-1
Цочмог халдварт өвчин	261	117	-144
Цусан суулга	-	1	1
Гепатит А	2	2	-
Скарлатин	1	3	2
Салхин цэцэг	27	50	23
Крансүх	-	1	1
Корь	195	1	-194
Хачигт рикеттиоз	-	1	1
Рож	1	2	1
Гар хөл амны өвчин	25	50	25
Сүрьеэ	10	6	-4
Нийт халдварт өвчин	354	173	-181

Зураг 8. Халдварт өвчин, тоогоор, сараар



2017 оны эхний 4 сарын байдлаар халдварт паразит өвчин 56 болж нийт халдварт өвчний 32.4 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 37 тохиолдлоор буюу 39.7 хувиар, цочмог халдварт өвчин 117 тохиолдол байгаа нь нийт халдварт өвчний 67.6 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс 144 тохиолдлоор буюу 55.2 хувиар тус тус буурсан байна.

Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 60.4 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 64.5 продициллээр буурсан байна.



ГЭМТ ХЭРЭГ:

Дүүргийн хэмжээнд 2017 оны эхний 4 сарын байдлаар 69 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 30.3 хувиар буюу 30 хэргээр буурсан байна. Хэрэг илрүүлэлт 63.2 хувь болж өнгөрсөн оны мөн үеэс 6.9 пунктээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 9. Бүртгэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2016 I-IV	2017 I-IV	Хэргийн өсөлт	Дүнд эзлэх хувь
Бүртгэгдсэн гэмт хэрэг	99	69	-30	100.0
Хүн амь	1	-	-1	-
Хүчин	4	-	-4	-
Дээрэм	1	-	-1	-
Танхай	4	2	-2	2.9
ББМГУчруулах	39	32	-7	46.4
Ашиглах	1	-	-1	-
Хулгай	21	16	-5	23.2
үүнээс: малын	-	2	2	12.5*
Залилан	4	4	0	5.8
ХАБЭсрэг	12	5	-7	7.2
Гэр бүлийн хүчирхийлэл	-	3	3	4.3
Бусад	12	7	-5	10.1
Хэрэг илрүүлэлт	56.3	63.2		

*-нийт хулгайн хэрэгт эзлэх хувиар тооцов.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн бүтцийг авч үзэхэд 46.4 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах /ББМГУчруулах/ хэрэг, 23.2 хувийг хулгайн хэрэг, 10.1 хувийг бусад гэмт хэргүүд, 7.2 хувийг хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг /ХАБЭ/ гэмт хэрэг, 5.8 хувийг залилангийн хэрэг, 4.3 хувийг гэр бүлийн хүчирхийллийн хэрэг, 2.9 хувийг танхайн хэрэг тус тус эзэлж байна. Малын хулгайн гэмт хэрэг 2 бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн хулгайн хэргийн 12.5 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд хүний амь, хүчин, дээрэм, ашиглах гэмт хэргүүд бүртгэгдээгүй байна.

Зураг 9. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг, сараар




Хүснэгт 10. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2016 I-IV		2017 I-IV	
	согтуугаар	гудамж талбайд	согтуугаар	гудамж талбайд
Бүгд	35	20	29	9
Хүний амь	1	-	-	-
Хүчин	3	-	-	-
Танхай	4	1	2	-
ББМГУчруулах	23	12	24	4
Хулгай	1	2	1	2
Гэр бүлийн хүчирхийлэл	-	-	1	-
ХАБЭсрэг	1	2	-	-
Бусад	2	3	1	3
Дүнд эзлэх хувь	35.4	20.2	42.0	14.5

2017 оны эхний 4 сарын байдлаар согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 29 болж өнгөрсөн оны мөн үеэс 17.1 хувиар буюу 6 хэргээр буурсан байна. Энэ нь тайлант хугацаанд бүртгэгдсэн гэмт хэргийн 42.0 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 6.6 пунктээр нэмэгдсэн байна. Мөн гудамж талбайд үйлдэгдсэн хэргийн тоо 9 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2.2 дахин бага буюу 11 хэргээр буурч, нийт гэмт хэргийн 14.5 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 5.7 пунктээр буурсан байна.

Зураг 10. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн эзлэх хувь, жил бүрийн I-IV сар




Зураг 11. Нийт гэмт хэрэг, үүнээс гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, жил бүрийн I-IV сар



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД:

2017 оны 4 сарын байдлаар дүүрэгт ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд 716 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 8.2 хувиар буюу 64 хүнээр, эмэгтэй ажилгүй иргэд 352 байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар буюу 13 хүнээр тус тус буурсан байна. Тайлант сард ажил идэвхтэй хайж байгаа 12 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

Зураг 12. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлгөөн



Тайлант сард ажил идэвхтэй хайж байгаа 130 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүний 52.3 хувь нь буюу 68 нь эмэгтэйчүүд байна. Мөн энэ хугацаанд 38 иргэн ажилд зуучлуулан орсон байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн ажилд орсон байдлыг авч үзэхэд:


- хязгаарлагдмал хариуцлагатай компанид – 36
- төсөвт байгууллагад – 1
- төрийн өмчит үйлдвэрийн газарт - 1 иргэн тус тус ажилд орсон байна.

Хүснэгт 11. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны ангиллаар

Үзүүлэлт	2016.IV	Дүнд эзлэх хувь	2017.IV	Дүнд эзлэх хувь
15-24 нас	167	21.4	136	19.0
25-34 нас	314	40.3	288	40.2
35-44 нас	182	23.3	167	23.3
45-60 нас	117	15.0	111	15.5
Бүгд	780	100.0	716	100.0

2017 оны 4 сарын байдлаар ажил идэвхтэй хайж байгаа бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны ангиллаар авч үзэхэд 19.4 хувь нь 16-24 насны, 41.0 хувь нь 25-34 насны, 23.8 хувь нь 35-44 насны, 15.8 хувь нь 45-60 насны ажилгүй иргэд эзэлж байна.

Зураг 13. Бүртгэлтэй ажилгүй иргэд /насны бүлгээр/



Зураг 14. Бүртгэлтэй ажилгүй иргэд, тоогоор, сараар



Хүснэгт 12. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролоор

Үзүүлэлт		Ажилгүй иргэд		Бүгдэд эзлэх хувь	
		2016.IV	2017.IV	2016.IV	2017.IV
Бүртгэлтэй ажилгүй иргэд		780	716	100.0	100.0
Үүнээс	Дээд	196	188	25.1	26.3
	Тусгай дунд	63	50	8.1	7.0
	Мэргэжлийн анхан шатны	94	71	12.1	9.9
	Бүрэн дунд	346	345	44.4	48.2
	Бүрэн бус дунд	54	47	6.9	6.6
	Бага	19	12	2.4	1.7
	Боловсролгүй	8	3	1.0	0.4

Зураг 15. Бүртгэлтэй ажилгүй иргэд /боловсролоор/



2017 оны 4 сарын байдлаар ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр ангилж үзэхэд 26.3 хувийг дээд, 7.0 хувийг тусгай дунд, 9.9 хувийг мэргэжлийн анхан шатны, 48.2 хувийг бүрэн дунд, 6.6 хувийг бүрэн бус дунд, 1.7 хувийг бага боловсролтой 0.4 хувийг боловсролгүй ажилгүй иргэд эзэлж байна.



ҮНЭ ХАНШ:


2017 оны 4 сарын хүнсний өргөн хэрэглээний 21 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.

Хүснэгт 13. Хүнсний барааны үнийн ажиглалт, 2017 оны 4 сарын дундаж үнэ


№	Хүнсний бараа	х.н	Хишиг-Уул супермаркет	Марал хүнсний дэлгүүр	Хэрлэн хүнсний зах	V&M супермаркет	Оранж супермаркет	
1	"Алтан тариа" гурил	Дээд	кг	1350	1300		1500	1350
		I зэрэг	кг	1100	1200		1200	1150
		II зэрэг	кг	900	900		1000	950
2	Будаа	цагаан	кг	2300	2000		2200	2200
		шар	кг	1200	800		1700	1150
3	Хонины мах	ястай	кг			7000		
		цул	кг			7500		
4	Үхрийн мах	ястай	кг			8500		
		цул	кг			7500		
5	Адууны мах, ястай	кг			6500			
6	Ямааны мах	кг		4500	4500			
7	Элсэн чихэр	кг	2300	2200		2200	2200	
8	Сүү /миний монгол/	Л	2200	2400				

9	Тараг /амтлаг/	л	1650	1600				
10	Цэцгийн тос, Орос	кг	3400	3500		3500	3100	
11	Байцаа	кг	1550	1500	1200	1500	1500	
12	Манжин	кг	1000	1000	1000	1000	1050	
13	Төмс	монгол	кг	600	800	700	800	750
14	Лууван	монгол	кг	800	800	900	800	950
15	Сонгино	хятад	кг	1100	1300	1200		1200
		монгол	кг	2500	2500	3000	2500	2700
16	Сармис, булцуу	кг	440		500	500	500	
17	Огурцы, хятад	кг	5000		4000	5000	4500	
18	Помидор, хятад /үрлэн/	кг	6500		5000	5000	5000	
19	Ургамлын тос/ sunny gold/	ш	3500	3600		3800	3450	
20	Өндөг	ш	380	330		350	350	
21	Талх	том 900 гр	ш	1600	1600		1500	1500
		Дунд 700 гр	ш	1400	1300		1400	1100
		жижиг 500 гр	ш	1100	900		800	800
		Есөн шанд /жижиг/	ш	900	1100		900	850
		Атар талх	ш	1200	1100		1200	1150

Зураг 16. "Алтан тариа" гурилын үнэ / жил бүрийн 4 сар/



Зураг 17. Нэг кг цул махны үнэ /жил бүрийн 4 сар/



Хүснэгт 14. Үйлчилгээний үнийн тариф /НӨТ-гүй үнэ/

Үзүүлэлт	Айл өрхөд	Аж ахуйн нэгж байгууллагад
Дулаан	1 м ² =522 төг	1м ³ =853 төг
Дулааны суурь тариф	40 м ² хүртлэх=3000 төг 40м ² - 80м ² = 5000 төг 81м ² –аас дээш = 10000 төг	-
Халуун ус	Өвөл 1 хүн=2500 төг /тоолуургүй/ 1м ³ =1187 төг /тоолууртай /	1гкал=54561 төг
	Зун 1 хүн=3500 төг /тоолуургүй/ 1м ³ =1187 төг /тоолууртай /	
Цэвэр ус*	1 хүн=5106 төг /тоолуургүй/ 1 л=0.63 төг /тоолууртай/ Суурь хураамж =1800 төг	1 л=1.20 төг /тоолуургүй/ 1 л=1.15 төг /тоолууртай/ 1 л=4.41 төг /зөөврөөр/
Бохир ус*	1 хүн=4830 төг /тоолуургүй/ 1 л=0.58 төг /тоолууртай/	1 л=1.20 төг /тоолуургүй/ 1 л=1.15 төг/тоолууртай/

*2015 оны 1 сарын 10-наас мөрдөж байгаа тариф

Хүснэгт 15. Цахилгааны үнийн тариф /НӨТ-гүй үнэ/

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
* Айл өрхөд борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	98.4
Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	118.2
2 тарифт тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	104.3
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	77.1
Сарын суурь тариф	төг/сар	2000.0
* Аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	128.5
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	209.8
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	77.1
3 тарифт тоолууртай /уул уурхай, үйлдвэрийн газар/		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	155.9
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	276.0
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	77.1


* 2015 оны 7 сарын 25-ны өдрөөс мөрдөж буй тариф

Хүснэгт 16. Түлш шатахууны үнэ

Шатахууны нэр төрөл	2016. XII	2016. I	2017. II	2017. III	2017. IV
АИ -76,80	1440	1440	1480	1480	1480
АИ -92,93	1540	1540	1630	1630	1630
Дизель түлш	1650	1650	1720	1720	1720

2017 оны 4 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд АИ-80 бензин 0.6 хувиар буюу 10 төгрөгөөр буурсан бол АИ-92 бензин 1.8 хувиар буюу 30 төгрөгөөр, дизель түлш 1.8 хувиар буюу 10 төгрөгөөр тус тус өссөн байна.


Зураг 18. Хот хоорондын зорчигч тээврийн үнэ /УБ-БН, БН-УБ/



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2017 оны 5 дугаар сарын 12 өдөр

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?



 Цахимаар:

www.1212.mn

Статистик мэдээллийн
нэгдсэн сан

 www.nso.mn

Та статистик мэдээллийг байнга
авч байхыг хүсвэл **ЭНД ДАРЖ**
бүртгүүлнэ үү

Энэ хэсэгт өөрийн e-mail
хаягаа бүртгүүлснээр
статистикийн мэдээллийг
цаг алдалгүй тогтмол авч
байх болно.

SOCIAL NETWORK

 [www.facebook.com/
Статистик-Мэдээлэл](http://www.facebook.com/Статистик-Мэдээлэл)

 [www.twitter.com/
statistic_mn](http://www.twitter.com/statistic_mn)



Ухаалаг гар утас, таблет
ашиглан статистик мэдээлэл
авах **ezStat** аппликейшн



Статистикийн хэвлэмэл
бүтээгдэхүүнийг унших
Монстат аппликейшн



Утсаар:



Лавлах утас

1900-1212